



ӨМГӨӨДЛИЙН
НИЙСЛЭД
АДВОКАЙТС
ХХК

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрх



www.niisleladvocate.mn



[niisleladvocate](https://www.facebook.com/niisleladvocate)



[@niisleladvocate](https://twitter.com/niisleladvocate)



[niisleladvocate](https://www.instagram.com/niisleladvocate)

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 4 дэх хэсэг

Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.




Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын
согог нь орчны саадтай нийлсний улмаас бусдын адил
нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар
нь хязгаарлагдсан хүнийг
"хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар
хөгжлийн бэрхшээлтэй хүнийг
"ажил олоход хүндрэлтэй иргэн" гэж үздэг.


Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах үүргийг хүлээдэг.


Тоон мэдээлэл



2019 оны байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 107.1 мянгад хүрч өмнөх онтой харьцуулахад 1.3 мянга (1.3%)-аар нэмэгджээ.



35-64 насныхан 64.4 мянга (61.1%) байна.



20-34 насныхан 21.7 мянга (20.2%)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаас илүү хувь нь эрэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

- ✓ Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх
- ✓ Тэгш оролцоог хангах;
- ✓ Сонголт хийх, хараат бус байх боломжийг хангах;
- ✓ Сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;



Хөдөлмөрлөх эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй.



Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхдээ олон улсын чиг хандлагын дагуу түгээмэл загвар хэрэглэхийг эрхэмлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих;
- Ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх;
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох;
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйл

Хөдөлмөрийн тухай хуулиас...



- ✓ 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө.

Ажлын байрны сонгон шалгаруулалт

- ✓ Төрийн байгууллага, хуулийн этгээд нь ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг харгалзан үзэх үүрэгтэй.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүн нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо түүний хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээ, шаардлагад тохирох тусламж, нэмэлт цаг ашиглах эрхтэй.

Ажил олгогчийн үүрэг



- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй болон одой ажилтныг хөдөлмөрлөх аятай нөхцөлөөр хангах
- ✓ Хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхагүй байх
- ✓ Албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлахгүй байх
- ✓ Хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэхгүй байх
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзахгүй байх, цалин хөлсийг ялгавартай тогтоохгүй байх;
- ✓ Мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх

Ажил олгогчийн үүрэг



- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгох
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах
- ✓ Соёл, урлагийн арга хэмжээнд оролцох, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ Аливаа хүчирхийллээс ангид хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох
- ✓ Дохионы хэлээр харилцах боломжийг бүрдүүлэх
- ✓ Гүйцэтгэж байгаа ажлын шинж байдлаас хамааран ажилтны саналыг харгалзан ажлын цагийг богиносгож болно.

Хориглолт



- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй, одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол тэдгээрийг уг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг **хориглоно**.
- ✓ Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг **хориглоно**.
- ✓ Цалин хөлс авч байгаа гэсэн шалтгаанаар ажлтын нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг нь зогсоохыг **хориглоно**.
- ✓ Эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хувь хүний нууцыг задруулахыг **хориглоно**.


Хамт олоны дэмжлэг

Хамтран ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ.

- ✓ Ялгаварлан гадуурхахгүй байх
- ✓ Зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих
- ✓ Ажил үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлэх, заавар, зөвлөгөө өгөх
- ✓ Хувийн нууцыг хадгалах
- ✓ Хамт олны дунд идэвхтэй, бие даасан гишүүн болохыг дэмжих



Гомдол, нэхэмжлэл гаргах эрх



- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүн хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл иргэн, хуулийн этгээдээ зөрчлийг арилгуулахыг шаардах, холбогдох хуульд заасны дагуу гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.
- ✓ Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хуульд заасан эрхийг хязгаарласан, ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг явуулсан гэж үзвэл хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхээ шууд болон төлөөллөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

01

Эрүүгийн хууль

11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх /хүндрүүлэх нөхцөл байдал /

13.13 Албадан хөдөлмөрлүүлэх

15.2 Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх

15.3 Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах /хүндрүүлэх нөхцөл байдал /

02

Зөрчлийн тухай хууль

10.12 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль зөрчих

10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих

12.5 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль зөрчих



ӨМГӨӨЛИЙН
НИЙСЛЭД
АДВОКЭЙТС
ХХК



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



www.niisleladvocate.mn



[niisleladvocate](https://www.facebook.com/niisleladvocate)



[@niisleladvocate](https://twitter.com/niisleladvocate)



[niisleladvocate](https://www.instagram.com/niisleladvocate)